



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Х.ТЭМҮҮЖИН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.03.21. № 107/786

танай _____-ны № _____-т

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт 3-хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ

100255006148

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 12 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“4.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн санаачлан боловсруулсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн санаачлан боловсруулсан хуулийн төслийг хэлэлцээд дараах саналыг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1.Хуулийн төслийн үзэл баримтлалд “төрийн байгууллагыг хуулийн этгээд гэж үзэх нь хууль бус юм.” гэж дурдаж, Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд “Энэ зүйлд заасан “хуулийн этгээд” гэх ойлголтод төрийн байгууллага хамаарахгүй” гэсэн тайлбар нэмэхээр тусгажээ.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4.1.1-д ““хуулийн этгээд” гэж Иргэний хуулийн 25.1-д заасан шинжийг агуулсан зохион байгуулалтын нэгдлийг;” ойлгоно гэж, 5.1-д “Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ.” гэж, 7.1.8-д улсын бүртгэлийн байгууллага “төрийн байгууллага, албан газар”-ыг хуулийн этгээдээр бүртгэхээр тус тус заасан.

Түүнчлэн, Иргэний хуулийн 25.1-д “Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ.” гэж, 30.2-т “Чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаар буюу хамтран хуулийн этгээд байгуулж болно.” гэж тус тус заасан.

Иймд дээрх хуулийн зохицуулалттай нийцүүлэн хуулийн төслийн үзэл баримтлалд өөрчлөлт оруулах нь зүйтэй байна.

2.Хуулийн төслийн 2, 3, 5 дугаар зүйлд “эрүүгийн хариуцлага” гэсэн ойлголтыг “ял, албадлагын арга хэмжээ” гэж өөрчлөх, эрүүгийн хуулийн зарим зүйлийг хасах талаар тусгажээ.

Мөн хуулийн төсөл санаачлагч нь хуулийн төслийн танилцуулгад албадлагын арга хэмжээ хэрэглэснийг эрүүгийн хариуцлага хүлээсэнд хамааруулж, хүний эрхийг дордуулж байгаа талаар дурджээ.

Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуульд ял, албадлагын арга хэмжээний талаарх ойлголт, түүний төрөл, хэмжээг нарийвчлан, ялгаатай байдлаар тодорхойлсон ба дээрх ойлголтуудыг нэгтгэн, эрүүгийн хариуцлага гэж томъёолсон.

Тодруулбал, Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлийн 2-т “Эрүүгийн хариуцлага нь энэ хуульд заасан ял, албадлагын арга хэмжээнээс бүрдэнэ.” гэж албадлагын арга хэмжээг эрүүгийн хариуцлагын нэг төрөл байхаар тодорхойлон хуульчилсан нь бусад хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан албадлагын арга хэмжээнээс ялгагдах нөхцөл нь болдог.

Гэмт хэрэг үйлдсэн хүнд Эрүүгийн хуульд заасан албадлагын арга хэмжээ хүлээлгэсэн нь гэмт хэрэг үйлдээгүй, гэм буруугүй гэсэн ойлголт болохгүй бөгөөд эрүүгийн хариуцлагын зорилгыг ханган “шударга ёсны зарчим”-д нийцүүлэн ялгамжтайгаар хариуцлага хүлээлгэж байгаа явдал юм.

Түүнчлэн, хуулийн төслийг дагалдуулан өөрчлөлт оруулахаар боловсруулсан 42 хуулийн төслөөс гадна Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуулиудад “Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэсэн зохицуулалт байгаа болохыг анхаарах нь зүйтэй.

Иймд Эрүүгийн хуульд заасан “эрүүгийн хариуцлага” гэсэн нэр томъёог шууд ял, албадлагын арга хэмжээ гэж бүхэлд нь механикаар өөрчилж, бусад салбар хуулиудад мөн дээрх байдлаар өөрчлөлт оруулах нь Эрүүгийн хуулийн системчлэлийг алдагдуулахаас гадна хууль ёсны болон шударга ёсны зэрэг зарчмуудад нийцэх эсэхийг нягтлах нь зүйтэй байна.

3.Хуулийн төслийн 3 дугаар зүйлд “Эрүүгийн ял, албадлагын арга хэмжээ нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн шинж чанар, учруулсан хохирлын хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна.” гэж тусгажээ.

Гэмт хэргийг халдлагад өртөж буй объектын шинж, төрлөөр нь зааглан Эрүүгийн хуулийн тусгай ангийн тодорхой бүлгүүдэд тусгаж, хөнгөн, хүнд гэж ангилан, оногдуулах эрүүгийн хариуцлагыг ялгамжтай тогтоосон.

Мөн гэмт хэргийн нийгмийн хор аюулын хэр хэмжээ болон гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдлыг Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тухайлсан гэмт хэргийн үндсэн болон хүндрүүлэх шинжид хамааруулж, ялын төрөл, хэмжээг тогтоохын зэрэгцээ Эрүүгийн хуулийн ерөнхий ангид эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал болгон хуульчилсан.

Гэтэл хуулийн төсөлд гэмт хэргийн шинж, нийгмийн хор аюулын хэр хэмжээг зөвхөн хохирлын хэр хэмжээгээр хязгаарласан нь Эрүүгийн хуульд заасан дээрх агуулгатай зөрчилдөж байгааг анхаарч, өөрчлөх шаардлагатай.

4.Хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “Хөгжлийн банкны тухай хууль зөрчих” үйлдлийг зөрчилд тооцож, хариуцлага хүлээлгэх агуулга бүхий 10.31 дүгээр зүйл нэмэхээр тусгажээ.

Энэ нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 16.1-д “Хууль тогтоомжийн төслийг үзэл баримтлалд нь нийцүүлэн боловсруулна.” гэж заасантай нийцэхгүй байх бөгөөд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Зөрчлийн тухай хуулийн 11.17 дугаар зүйлд “Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль зөрчих” үйлдлийг зөрчилд тооцож, хариуцлага хүлээлгэж байх тул Зөрчлийн тухай хуульд 10.31 дүгээр зүйл нэмэхийг хасах нь зүйтэй.

5.Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.1-д “хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулахдаа энэ хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, эсхүл энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийнэ” гэж, 16.3-т “Хууль тогтоомжийн төсөл боловсруулахдаа бусад хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт, тэдгээрийг дагаж гарах шийдвэрийн төслийг хамт боловсруулж, холбогдох тооцоо, судалгаа хийсэн байна” гэж, 40.1.2-т “Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төсөлд “хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлал, товч болон дэлгэрэнгүй танилцуулга, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан, эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайлан”-г хавсаргана” гэж тус тус заасны дагуу хуулийн төслийн бүрдүүлбэрийг хангаж, хуулийн төслийн холбогдох судалгааг бүрэн хийх нь зүйтэй байна.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР